



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/518

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/a/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ээлжит VII хуралдааны 05 дугаар тогтоол, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилгын салбарын мэргэжилтэй ажилчид, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдын дунд зохион байгуулах ажил мэргэжлийн ур чадварын тэмцээн, орон нутгийн барилгын салбарын “Эрдэнэт барилга 2017” зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах 6000000 /зургаан сая/ төгрөгийг Засаг даргын бусад зардал “Хангайн бүсийн сургалтын төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, мэргэжилтэй ажилчдын дунд бүсийн ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулах зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ